# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (320)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнийг одон медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Ажилд томилох тухай*
- *Нэг удаагийн дэмжлэг үзүүлэх тухай*
- *Цомын загвар батлах тухай*
- *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2003 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны есдүгээр сарын 22 № 35 (320)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 516. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 166 | 829 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 517. | Ажилд томилох тухай | Дугаар 179 | 834 |
| 518. | Нэг удаагийн дэмжлэг үзүүлэх тухай | Дугаар 180 | 835 |
| 519. | Цомын загвар батлах тухай | Дугаар 181 | 835 |
| 520. | Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 183 | 836 |
| 521. | Хамгаалалтын бүс тогтоох тухай | Дугаар 190 | 836 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 9 дүгээр сарын 3–ны өдөр** **Дугаар 166** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, хөдөө аж ахуй, биеийн тамир спорт, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Төмөрдаваагийн Бэхбат -Нийслэлийн "МИАТ" ХК-ийн В-737-800 онгоцны дарга
2. Цэвэгжавын Мааньгүмбэн -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор дунд сургуулийн бага ангийн багш

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Дүгэрсүрэнгийн Ариунболд -ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
2. Паламын Балдан -Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын малчин
3. Дан-Аагийн Банзрагч -ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
4. Доржийн Батбаяр -ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээнийн ажилтан
5. Чогсомын Батсүх -Өмнөговь аймгийн Баяндалай сумын дунд сургуулийн захирал
6. Гомбын Батчунаг -Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн засварчин
7. Пүрэвдаваагийн Баянмөнх -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн шохойн зуухны машинист
8. Жавзангийн Баярсайхан -Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн "Биоекомбинат" ТӨҮГ-ын цехийн эрхлэгч, их эмч
9. Санжаагийн Будням -Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч
10. Думаагийн Буянтогтох -Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн "Биокомбинат" ТӨҮГ-ын захиргааны удирдлагын менежер
11. Дашийн Бямбаа -Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг дарга
12. Галцогтын Галбаатар -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн санхүүгийн хэлтсийн дарга
13. Дамдингийн Долгор -Хэнтий аймгийн Хэрлэн сумын өндөр настан, ахмад багш
14. Хайнзангийн Дорж -ШУА-ийн Физик, химийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
15. Очирбатын Доржсүрэн -Ховд аймгийн Мянгад сумын Засаг дарга
16. Чилхаажавын Дулмаа -Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК- ийн лаборант
17. Гунгаагийн Жаргалсайхан -"МИАТ" ХК-ийн В-737-800 онгоцны дарга
18. Гэндэнгийн Зулхүү -Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн халдвартын тэнхмийн зөвлөх эмч
19. Жамбын Ичинноров -Булган аймгийн Сэлэнгэ сумын дунд сургуулийн түүх, газар зүйн багш
20. Дулмаагийн Лундаа -Төр, засгийн үйлчилгээний автобаазын жолооч
21. Занын Лхагва -Дархан-Уул аймгийн үйлдвэр, худалдааны "Сайхан Монгол" ХХК-ийн захирал
22. Занын Маамуу -Увс аймгийн Баруунтуруун сумын дунд сургуулийн зураг төслийн багш
23. Эмээлжигжидийн Намсрай -Техник, технологийн коллежийн захирал
24. Хүрэлийн Нядсүрэн -Сэлэнгэ аймгийн Мандал сумын мал эмнэлэг, үржлийн албаны улсын байцаагч
25. Дамбаравжаагийн Оюунболд -"МИАТ" ХК-ийн А-310-300 онгоцны дарга
26. Дэжидийн Оюунжаргал -Улсын үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин
27. Чүлтэмсүрэнгийн Раднаабазар -Орхон аймгийн "Хангарьд" спорт клубийн дасгалжуулагч
28. Анандын Рэгзэн -Баянхонгор аймгийн галуут сумын Засаг дарга
29. Цогтын Сайннямбуу -Нийслэлийн зам тээврийн газрын зохион байгуулагч
30. Равчигийн Содов -"НИК" ХК-ийн хяналтын газрын байцаагч
31. Алтангэрэлийн -Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн "Биокомбинат" ТӨҮГ-ын лабораторийн эрхлэгч, их эмч
32. Цамбын Түдэв -Завхан аймгийн Отгон сумын Засаг дарга
33. Хорлоожавын Түмэннасан -ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн секторын

эрхлэгч

34. Пагамын Хосбаяр -ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн төслийн удирдагч

35. Насантогтохын Хүүхэнжимээ -ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн төслийн удирдагч

36. Жигмэдийн Цэдэн -Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын дунд сургуулийн бага ангийн багш

37. Жамбалын Цэнджав -Нийслэлийн Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

38. Чойдогийн Цэрэн -ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

39. Дуламсүрэнгийн Цэрэнгомбо -Баянхонгор аймгийн Тээврийн зохицуулалтын газрын дарга

40. Цэрэндоржийн Цэрэнжав -Нийслэлийн зам тээврийн газрын зохион байгуулагч

41. Цэндсүрэнгийн Чимиддорж -"МИАТ" ХК-ийн АН-24 онгоцны дарга

42. Пунцагбалжирын Чулуунбаатар -"Монголросцветмет" нэгдлийн харьяа Төв аймгийн Заамар сум дахь "Зэрэгцээ" алтны үйлдвэрийн уулын мастер

43. Чурхайн Шаалуу -Эрчим хүчний зохицуулалтын газрын ажилтан

44. Маналжавын Шагдарсүрэн -Нийслэлийн "Шагдарсүрэн" хувийн эмнэлгийн захирал

45. Зумияны Шакей -Баян-Өлгий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байцаагч, инженер

46. Доржийн Шаравнямбуу -Баянхонгор аймгийн Заг сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

Маахүүгийн Алтангэрэл -Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, Иргэний хамгаалалтын штабын дарга, дэд хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Шаравын Аганов - Төв аймгийн Заамар сум дахь "Шижир алт" ХХК-ийн Заамарын алтны үйлдвэрийн цахилгааны засварчин

2. Довдонгийн Андрей -Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

3. Түвшингийн Андуу -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн бутлуурын цехийн засварчин

4. Тунтгарын Балжинням -Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын малчин

5. Дамбийжаагийн Батбаяр -Дорноговь аймгийн Өргөн сум дахь Өргөний уулын үйлдвэрийн тэсэлгээчин

6. Намсрайжавын Батбаясгалан -Төр, засгийн үйлчилгээний автобаазын нэгдүгээр хэсгийн дарга

7. Сэрээтэрийн Батмөнх -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн уул тээврийн цехийн жолооч

8. Дашнамжилын Батсайхан -Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх Стандартчилал, хэмжилзүйн төвийн дарга

9. Довдонгийн Баттөмөр -Хөвсгөл аймгийн Рашаант сумын "Улаан-Од" ХХК-ийн нягтлан бодогч

10. Ламжавын Батцоож -Нийслэлийн Зам тээврийн газрын орлогч дарга

11. Данзангийн Батчулуун -"МИАТ" ХК-ийн автобаазын шатахуун тээврийн жолооч

12. Довдонгийн Баяраа -Усан спорт сургалтын төвийн багш дасгалжуулагч

13. Чимэдийн Баярдалай -Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн инженер

14. Долгоржавын Баярмагнай -Төр, Засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

15. Сангидоржийн Баярсайхан -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн ахлах мастер

| | |
|---|---|
| 16. Гажидын Буд | - Өмнөговь аймгийн Хүрмэн сумын малчин |
| 17. Магсарын Буянаа | -"МИАТ" ХК-ийн харьяа "Агросервис" ХХК-ийн менежер |
| 18. Шаравын Галбадрах | -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн тоног төхөөрөмжийн засварчин |
| 19. Цагаан-Өвгөний Галсандорж | - Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүрс оношлогооны их эмч |
| 20. Бархүүгийн Ганбаатар | - "Монголросцветмет" нэгдлийн харьяа Төв аймгийн Заамар сум дахь "Зэрэгцээ" алтны үйлдвэрийн жолооч |
| 21. Сумъяагийн Ганболд | - Улаанбаатар төмөр замын Сайшанд зангилгааны 4 дүгээр ангийн дарга |
| 22. Доржийн Гансүх | -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн ерөнхий механик |
| 23. Батбазарын Гантөмөр | -Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |
| 24. Арьягийн Гарамжав | -ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 25. Лхагвын Гиймаа | -Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн тооцооны техникч |
| 26. Дааханхүүгийн Гомбосүрэн | -Увс аймгийн Зүүнхангай сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 27. Эрдэнэсамбуугийн Даваажанцан | -Нийслэлийн "Дулаан цахилгаан станц-4" ТӨХК-ийн инженер |
| 28. Гончоогийн Давааням | -Төр, засгийн үйлчилгээний автобаазын жолооч |
| 29. Цэндийн Дагвадорж | -Төв аймгийн Заамар сум дахь "Шижир алт" ХХК-ийн Заамарын алтны үйлдвэрийн автокраны жолооч |
| 30. Лувсанбалдангийн Дайриймаа | -Нийслэлийн зам гүүр, Засварын "Эрдэнэ зам" ХК-ийн жолооч |
| 31. Хандын Дарьхүү | -Өмнөговь аймгийн Ханхонгор сумын мэргэжлийн сургалттай сургуулийн монгол хэлний багш |
| 32. Лувсанцэрэнгийн Дашдэндэв | -Төр, засгийн үйлчилгээний автобаазын жолооч |
| 33. Лувсанцэрэнгийн Дашцэрэн | -Халдварт өвчин судлалын үндэсний төвийн прогнозчлолын багийн ахлагч |
| 34. Хорлоогийн Долгорсүрэн | -МУЗН-ийн Баянхонгор аймгийн хорооны нарийн бичгийн дарга |
| 35. Ишмаагийн Должин | -"МИАТ" ХК-ийн харьяа "МИАТ Кэтеринг" ХХК-ийн диспетчер |
| 36. Халтарын Дорж | -Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн жолооч |
| 37. Ламжавын Дугарцэнд | -Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент шохой" ХК-ийн тээвэр, борлуулах цехийн илчит тэрэгний машинч |
| 38. Ванчинсүрэнгийн Дуламжав | -Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн хангамжийн мэргэжилтэн |
| 39. Лувсандоржийн Дуламжав | -Дорноговь аймгийн Хөвсгөл сумын малчин |
| 40. Доржийн Дуламрагчаа | -Хэнтий аймгийн Дархан сум дахь Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн тэсэлгээчин |
| 41. Батсүхийн Дунжий | -Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуулийн биологийн багш |
| 42. Лувсангийн Дүүжий | - Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын мал эмнэлэг, үржлийн "Чанартай сүрэг " ХХК-ийн захирал |
| 43. Цэрэндоржийн Дэмчигжав | - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн мастер |
| 44. Сосорбарамын Жавзан | - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 45. Санжжамцын Жанцанбал | - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн засварчин |
| 46. Цэрэнгийн Жаргалсайхан | - Увс аймгийн Баруунтуруун сумын Засаг дарга |
| 47. Цэрэнцоогийн Жаргалсайхан | - Дорноговь аймгийн Өргөн сум дах Өргөний уулын үйлдвэрийн жолооч |
| 48.Цамбын Жигдэн | - Радио нэвтрүүлэх төв станцын ерөнхий нягтлан |

бодогч

49. Равжирын Зориг - Дорноговь аймгийн Айраг сум дахь Айргын уулын үйлдвэрийн экскаваторчин

50. Зундуйн Лхагвасүрэн - Клиникийн 3-р нэгдсэн эмнэлэгийн рентген оношлогооны тасгийн эрхлэгч, их эмч

51. Лодойжанцангийн Лхагвасүрэн - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн дохиолол хамгаалалтын инженер

52. Тугалыг Минжмаа - Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн даатгалын улсын байцаагч

53. Баатарын Мягмар - Баянхонгор аймгийн Галуут сумын Баянхонгор багийн Засаг дарга

54. Даржаагийн Мягмарсүрэн - Хөвсгөл аймгийн Жаргалант сумын холбооны салбарын эрхлэгч

55. Лувсанбатын Наваандорж - Сэлэнгэ аймгийн сайхан сумын Хөтөлийн "Цемент шохой " ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал

56. Самбуугийн Нарангэрэл - Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн

57. Нямхүүгийн Нарангэрэл - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны газрын дарга

58. Пүрэвжавын Наранцэцэг - Нийслэлийн Зам тээврийн газрын ахлах менежер

59. Пүрэвжавын Наранцэцэг - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн турбин цехийн машинч

60. Сономын Нармандах - Нийслэлийн үйлдвэр худалдааны "Говь " ХК-ийн нягтлан бодогч

61. Сэнгээгийн Нина - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 42-р дунд сургуулийн монгол хэлний багш

62. Доржийн Норов - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн борлуулалтын албаны дарга

63. Балдандоржийн Нямдорж - Хөвсгөл аймгийн Рашаант сумын Засаг дарга

64. Лувсандашийн Очирхуяг - Радио нэвтрүүлэх төв станцын жолооч

65. Зинамидэрийн Оюунчимэг - Сэлэнгэ аймгийн Хөтөлийн "Цемент " ХК-ийн лабарторийн ахлах инженер

66. Шаравын Пүрэв -Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын засаг даргын тамгын газрын түшмэл

67. Лувсанбазарын Пүрэвжав -Улсын мэргэжлийн хяналтын газрын Буянт-Ухаа боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч

68. Лувсандоржийн Пүрэвжав - Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын дунд сургуулийн захирал

69. Рэнцэнхандын Пүрэвжав - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн турбин цехийн мастер

70. Ламжавын Пүрэвдорж - Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын "Усан зам " ХК-ийн ерөнхий механикч

71. Пэрэнлэйн Пүрвээ - Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын сантехникч

72. Нанзадын Ролгоржав - Олон улсын хүүхдийн "Найрамдал " төвийн тогооч

73. Жамсрангийн Рэнцэн - Нийслэлийн зам гүүр засварын "Эрдэнэ зам" ХК-ийн жолооч

74. Ванчинжавын Сандагдорж - ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч

75. Тахузагийн Самей - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын "Хотгор " ХК-ийн экскаваторчин

76. Жигжидсүрэнгийн Сосорбарам - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 82-р цэцэрлэгийн эрхлэгч

77. Өлзиймаагийн Сүсрэндэрэм - Нийслэлийн "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн турбин цехийн засварчин

78. Бавуугийн Тунгалаг - Нийслэлийн Ус , суваг ашиглалтын инженер

79. Хандын Түвшинбаяр - Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжил

зүйн төвийн хэмжүүрийн улсын шалгагч

80. Өлзийтэгшийн Түмэндэмбэрэл - Өвөрхангай аймгийн засаг даргын Тамгын газрын нийгмийн даатгалын улсын байцаагч

81. Дашравдангийн Ундрах - Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлэгийн хяналтын улсын байцаагч

82. Дамбийн Хишигбаатар - “МИАТ” ХК-ийн харьяа “Агросервис ” ХХК-ийн шалгагч инженер

83. Доржийн Хоролжав - Увс аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга

84. Шүхэрийн Хоролсүрэн - ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

85. Лувсан-Осорын Хөх-Өвгөн - Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын дунд сургуулийн орос хэлний багш

86. Төрийн Цагаач - Хөвсгөл аймгийн Рашаант сумын “Улаан-Од” ХХК-ийн комбайнч

87. Сэдийн Цэвэлмаа - Ус , цаг уурын хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч

88. Батсүхийн Цэвээн - Нийслэлийн “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн инженерийн албаны дарга

89. Дэлэгдоржийн Цэрэнпил - Техник Технологийн коллежийн салбарын эрхлэгч

90. Лхамсүрэнгийн Чинзориг - Нийслэлийн Баянгол дүүргийн “Эрдмийн Ундраа” цогцолбор сургуулийн ерөнхий захирал

91. Сангажавын Чинзориг - Өмнөговь аймгийн Булган сумын дунд сургуулийн багш

92. Балдангийн Чимэдцэрэн - Үйлдвэр худалдааны яамны Бодлого зохицуулалтын газрын орлогч дарга

93. Чимэддоржийн Чимэдцэрэн - ШУА-ийн Филисофи, социологи , эрхийн хүрээлэнгийн референт

94, Самдангийн Шийрэв-Адъяа - ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн нийгмийн секторын эрхлэгч

95. Санжаасүрэнгийн Шинэжамц - “МИАТ” ХК-ийн АН-24 онгоцны дарга

96. Дангаагийн Энхтайван - ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн нийгмийн секторын эрхлэгч

97. Гэндэнгийн Эрдэнэсүрэн - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын “Хотгор ” ХК-ийн уулын мастер

98. Чимэддоржийн Эрдэнэчимэг - Олон улсын хүүхдийн “Найрамдал ” төвийн арга зүйч багш

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Рэндоогийн Даваадорж - Зэвсэгт хүчний Жанжин штабын хүн эмнэлгийг хэлтсийн зөвлөх их эмч, дэд хурандаа

2. Чимэддоржийн Ерөөлтцэнгэл - БНАКУ дахь НҮБ-ын энхийг сахиулах ажилгааны цэргийн ажиглагч офицер, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 8 дугаар сарын 6–ны өдөр** **Дугаар 179** **Улаанбаатар хот**

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Батзоригтын Эрдэнэбатыг Батлан хамгаалахын дэд сайдаар томилсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Батлан хамгаалахын сайд Ж.ГҮРРАГЧАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 8дугаар сарын 6–ны өдөр** **Дугаар 180** **Улаанбаатар хот**

### Нэг удаагийн дэмжлэг үзүүлэх тухай

Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн эрчим хүчний үйлдвэрүүд 2003 оны эхний хагас жилд үйлдвэрлэсэн цахилгаан, эрчим хүчний 35-47.4 хувийг дотоод хэрэглээ, шугамын болон зүй бус алдагдалд алдаж, борлуулсан эрчим хүчний 70-80 хувийг бичиж, бичсэн эрчим хүчнийхээ үнийн 57.2 хувийг хурааж ихээхэн хэмжээний орлогоо алдаж байгаагаас санхүүгийн хувьд хүнд байдалд орж өвлийн бэлтгэлээ хангах, их засвараа хийхэд хөрөнгийн хомсдолд оржээ.

Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгууд төлөвлөгөөт алдагдлаа хэтрүүлсний зэрэгцээ дээрх 4 аймаг нийтдээ 670 гаруй сая төгрөгийн авлага үүсгэсэн, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгууд цахилгааны нэгжийн өртгөө төлөвлөсөн хэмжээнээс 4.78-11 төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Засгийн газраас дээрх 4 аймагт удаа дараа санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа боловч өр авлагаа бууруулах, өртөг зардлаа хямдруулан ашигтай ажиллах, байцаагч, хэрэглэгч нарын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.

Аймгуудын эрчим хүчний үйлдвэрүүдийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлж, алдагдлыг бууруулах, цахилгаан, эрчим хүч хэрэглэсний төлбөрийг бүрэн хураах, үйлдвэрлэл-борлуулалтад тавих хяналт шалгалтыг сайжруулах, эрчим хүчний өртөг зардлыг хямдруулах, өр авлагыг барагдуулах зэрэг тодорхой ажил зохион байгуулж, дүнг Засгийн газарт илтгэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгуудын эрчим хүчний үйлдвэрийн 2003-2004 оны өвлийн бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дизелийн цахилгаан станцуудын их засварт шаардагдах 620.0 (зургаан зуун хорин) сая төгрөгийг 2003 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дунд зохицуулалт хийж санхүүжүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Санхүү, эдийн засгийн сайд Ч.УЛААН**

**Дэд бүтцийн сайд Б.ЖИГЖИД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 8 дугаар сарын 6–ны өдөр** **Дугаар 181** **Улаанбаатар хот**

### Цомын загвар батлах тухай

Монгол-Японы ард түмний найрамдалт харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, сумо бөхчүүдийн алдар гавьяаг хөхиүлэн дэмжих, үндэсний соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор мэргэжлийн сумо бөхийн дээд зиндаанд түрүүлсэн бөхөд олгодог Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит цомын шинэчилсэн загвар шалгаруулах ажлын хэсгийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн сумо бөхийн дээд зиндаанд түрүүлсэн бөхөд олгодог Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит шилжин явах цомын шинэчилсэн загвараар уран бүтээлч Д.Эрдэмбилэгийн зохиосон “Гурван цагийг билэгдсэн бөхчүүд” бүтээл, цомын батламж “гэрэгэ”-г баталсугай.

2. Цом хийлгэх зардалд шаардагдах 18,592.5 /арван найман сая таван зуун ерэн хоёр мянга таван зуун/ мянган төгрөгийг шийдвэрлэх, түүнчлэн “гэрэгэ”-ний зардлыг тухай бүр санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Санхүү, эдийн засгийн сайд Ч.УЛААН**

**Эрүүл мэндийн сайд П.НЯМДАВАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 8 дугаар сарын 6–ны өдөр | Дугаар 183 | Улаанбаатар хот

### Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай

Төсвийн удирдлага, менежментийн шинэ тогтолцоог нэвтрүүлж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төсвийн байгууллагын санхүүжилтийг хянаж олгох талаар мөрдөж байгаа журмыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Нэгдсэн төсвийн тухай хуульд нийцүүлэн шинэчилж энэ оны IY улирлаас эхлэн мөрдүүлэхийг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Төсвийн байгууллагын ерөнхий менежер нь байгууллагынхаа үйл ажиллагааг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Нэгдсэн төсвийн тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд удирдан явуулж байгаа эсэх, орон тоо, цалингийн санг тухайн жилийн батлагдсан төсөв, Засгийн газраас баталсан тухайн салбарын орон тооны дээд хязгаарт багтаан тогтоосон эсэх, түүнийгээ хэрхэн мөрдүүлж байгаад хяналт тавьж ажиллахыг эрхэлсэн сайд нарт үүрэг болгосугай.

3. Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдад даалгах нь:

а/төсөвт байгууллага, агентлаг нь төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогоор батлагдсан төсвийн санхүүжилтээс гадуур нэмэлт бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13.3-т заасан шаардлагыг хангасан байх зарчмыг мөрдлөг болгосугай;

б/харьяа байгууллагын санхүүжилтийн хуваарьт шаардлагатай тохиолдолд улирлаар зохицуулалт хийж байсугай;

в/харьяа байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирлын тайланд хийсэн нэгдсэн дүгнэлт, танилцуулгыг жил бүрийн 5, 8, 11 дүгээр сарын 10-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайлан, дүгнэлтийг дараа оны 3 дугаар сарын 10-ны дотор Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлж байсугай.

4. Төсөвт байгууллага, агентлагийн төсвийн хөрөнгө хэмнэх, өөрийн нэмэлт орлого олох сонирхлыг урамшуулах зорилгоор төсөвт байгууллагын харилцах дансны жилийн эцсийн үлдэгдлийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13.3-т нийцүүлэн тухайн байгууллага нь зарцуулж байх зарчмыг цаашид хэвшил болгохыг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

5. 2004 онд төрийн өмч, хөрөнгө, улсын өр төлбөрийн бүртгэл, тооллого явуулахтай холбогдуулан зохих бэлтгэлийг хангахыг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд, тооллого явуулахад шаардагдах зардлыг тооцож ирэх оны төсөвт тусгахыг Сангийн, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.

6. "Төрийн захиргааны шинэчлэл" төслийн 1 дүгээр үе шат хэрэгжиж дууссан, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан "Хөтөлбөрийн хүрээг өргөжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Сангийн, эдийн засгийн сайд** **Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 8 дугаар сарын 27–ны өдөр | Дугаар 190 | Улаанбаатар хот

### Хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот, Хөвсгөл, Хэнтий, Төв аймгийн нутаг дэвсгэрт оршдог түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Уушгийн өврийн буган чулууны цогцолборын хамгаалалтын бүсийг 42.0 га, Аваргын балгасын хамгаалалтын бүсийг 15.6 га, Дарь эхийн сүмийн 2 чулуун баганын хамгаалалтын бүсийг 0.07 га газар байхаар тус тус тогтоосугай.

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүрэн байдлыг хангаж, хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглох арга хэмжээ авахыг дээрх аймгийн болон нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н. Энхбаяр**

**Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд** **А. Цанжид**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 1

☎ 329487